

### **УУХҮЯ-д хандсан саналууд**

1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам нь Сангийн яам, Эдийн засгийн хөгжлийн яам, Ашигт малтмал, газрын тосны газартай хамтран дэд ажлын хэсэг байгуулж, Монгол улсын хэмжээнд аймаг орон нутагт байгуулсан бүх гэрээний жагсаалтыг нэгдсэн байдлаар гаргах;
2. Нээлттэй нийгэм форумын ажиллуулж байгаа гэрээний ил тод байдлын [www.iltodgeree.mn](http://www.iltodgeree.mn) порталыг УУХҮЯ, ОҮИТБС-ын ажлын албаны аль нэг тал нь хүлээн аваад, шинэчлээд явах хэрэгтэй байна. Иргэний нийгмийн байгууллага дээр төрийн байгууллагуудын ийм их том өгөгдөл мэдээлэл байна. Үүнийг 2019 оны программаар явж байгаа учраас шинэчлэл хийх шаардлагатай байна.
3. Цөмийн Энергийн Газар нууц гээд гэрээгээ тавьдаггүй. Гэрээний үндсэн текстийн нарийн анализ хийвэл нууцлах шаардлага байдаггүй.
4. Байршуулж чадаагүй уул уурхайн гэрээнүүдийг яагаад нууцлаад байгааг тодруулах.
5. ОҮИТБС-ын бие даасан хуулийг батлуулах;

### **Сангийн Яаманд хандсан саналууд**

1. Сангийн яам Төрийн өмчийн компаниудын борлуулалтын гэрээний жагсаалтыг гаргаж өгөх;
2. Шилэн данс болон дата мэдээллийн сангуудыг мэдээллийн сан дээрээ дата боловсруулалт хийгдэж график болон бүлэглэсэн байдлаар харуулдаг учир Сангийн яамны датаг ажлын алба дээр төвлөрүүлж системийн шинэчлэл хийх.
3. Ил тод байдлын тухай нэгдмэл мэдээллийн санг бий болгохь өөрөөр хэлбэл, татвар, шилэн данс, ОҮИТБС-ийн бүх мэдээллийг нэгтгэх;
4. Дэд Ажлын хэсэг байгуулаад Монгол улсын хэмжээнд 2021 оноос хойш байгуулсан уул уурхайн гэрээг нэгтгэх;

### **Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын Газарт хандсан саналууд**

1. Шилэн дансны хуулийг 34% -н эзэмшилтэй цөөхөн компани байдаг тул хэрэгжүүлэхэд төвөгтэй бус тул хуулинд хамруулах арга хэмжээ авах.
2. Төрийн өмчийн компаниуд туслан гүйцэтгэгч компаниудынхаа гэрээн дээр шилэн дансны мэдээллээ тавь гээд тавьчихад болох тул гэрээнд холбогдох заалтыг оруулах.
3. Төрийн өмчийн компаниуд улиралд нэг удаа санхүүгийн тайлангаа шилэн данс дээр тавих.
4. ОҮИТБС-н Жилийн нэгдсэн тайлан дээр мэдээлэл дутуу чанаргүй байдаг тул нэгтгэл тайлан бэлтгэдэг ажлын даалгаврыг сайжруулах ажлын хэсэг байгуулах. Нэгтгэл тайлан хийж байгаа аудиторын ажил сайжирвал дагаад бусад мэдээллүүд сайжирах боломжтой.
5. Маш олон тайлан гаргаад байгаа. Татварт өгч байгаа тайланг ОҮИТБС өгч байгаа тайлантай холбох, нийгмийн даатгалын тайлан, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт өгдөг тайлантай холбож хялбарчлах.
6. Төрийн өмчийн компаниудын аудитын тайлан, гүйцэтгэлийн аудитыг Иргэний нийгмийн байгууллага хянах;

### **Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хандсан саналууд**

1. Тавантолгойн С зөвшөөрөл ил тод байна. Нүүрсний Сонсголын мэдээллийг ил тод болгох.
2. Шилэн дансны хуулийг Төрийн өмчийн компаниуд хэрэгжүүлж байна. Төрийн өмчийн оролцоотой болон хяналтын багц эзэмшдэг компаниуд энэ хуулийн дагуу тайлагнах үүрэгтэй. Эрдэнэс Монгол нэгдэл гэхэд маш олон охин компанитай. Хуулиар хамааралтай компаниудаа тайлагнах.

## **Эрдэнэс Монгол Нэгдэлд хандсан саналууд**

1. Компаниудын мэдээлэл зөрөөтэй байдлыг өөрчлөх. ТӨБЗГ-аас төрийн өмчийн компаниудын статистик гаргадаг. Зарим зүйл нийцэхгүй байна. Эрдэнэс Монгол нэгдэл сайтаа саяхнаас шинэчилсэн байна. Шилэн дансны сайтад маш их мэдээлэл байдаг. Зарим тохиолдолд мэдээллээ дутуу тавьдагаа засах.
2. Эрдэнэс Монголын охин компаниудын санхүүгийн мэдээллийг шилэн дансанд байрлуулах. Шилэн дансны хуулийг Төрийн өмчийн компаниуд хэрэгжүүлж байна. Төрийн өмчийн оролцоотой болон хяналтын багц эзэмшдэг компаниуд энэ хуулийн дагуу тайлагнах үүрэгтэй. Эрдэнэс Монгол нэгдэл гэхэд маш олон охин компанитай. Хуулиар хамааралтай компаниудаа тайлагнах.
3. Эрдэнэс Монгол олон охин компанитай. Түүний дор хэдэн компани байгаа гэдэг нь тодорхой биш. Үүнийг ТӨБЗГ бүртгэдэг эсэх. Ийм компаниудыг ил тод болгох.
4. Эрдэнэс Монгол нэгдлийн Худалдан авалтын хяналтад Иргэний нийгмийн байгууллагын ролцоог сайжруулах. Одоо нэг л байгууллага хяналт тавьж оролцдог.

## **Оюу Толгой ХХК-д хандсан саналууд**

1. Шилэн дансны сайтад маш их мэдээлэл байдаг. Зарим тохиолдолд мэдээллээ дутуу тавьдаг. Оюу Толгой ХХК санхүүгийн ил тод байдал сул байна, сайжруулах.
2. Эрдэнэс Монголын гэрээт 1000 гаруй, Оюу Толгойн гэрээт 600-аад компани байдаг. Өөрөөр хэлбэл Эрдэнэс Тавантолгой ХК-аас туслан гүйцэтгэгч, хамгийн доод талын цэг хүртэл мэдээлэл нь ил тод байх;
3. Оюу толгой ХХК санхүүгийн тайлангаа илт тод болгочихвол иргэд үнэн зүйлийг тодорхой ойлгох болно. Хэрэв үнэн зөв мэдээллийг авч чадвал эргээд компанид хандах эерэг хандлагыг бий болгох боломжтой.

## **Ажлын хэсэг, Үндэсний зөвлөлд хандсан саналууд**

1. Төрийн өмчийн компаниудын талаар Ажлын хэсэг, Үндэсний зөвлөл хамтарч томоохон хэлэлцүүлэг хийх.
2. ОУИТБС-ын ажлын албаны санхүүжилтийг хараат бус байхаар шийдэх.
3. Үндэсний баялгийн сангийн хууль батлагдсан учир ОУИТБС-аа баялгийн сантай яаж холбох вэ гэсэн хэлэлцүүлэг хийх.
4. Дэд Ажлын хэсэг байгуулаад Монгол улсын хэмжээнд хэдэн гэрээ байгааг тодруулж, хэдэн нь ил тод байх ёстойг ойлгомжтой болгох.
5. Нээлттэй нийгэм форумын ажиллуулж байгаа гэрээний ил тод байдлын [www.iltodgeree.mn](http://www.iltodgeree.mn) порталыг УУХҮЯ, ОУИТБС-ын ажлын албаны аль нэг тал нь хүлээн аваад, шинэчлээд явах хэрэгтэй байна. Иргэний нийгмийн байгууллага дээр төрийн байгууллагуудын ийм их том өгөгдөл мэдээлэл байна. Үүнийг 2019 оны программаар явж байгаа учраас шинэчлэл хийх шаардлагатай байна.
6. Цөмийн Энергийн Газар нууц гээд гэрээгээ тавьдаггүй. Гэрээний үндсэн текстийн нарийн анализ хийвэл нууцлах шаардлага байдаггүй.
7. Байршуулж чадаагүй уул уурхайн гэрээнүүдийг яагаад нууцлаад байгааг тодруулах.

## **ОУИТБС-ын Ажлын албанд хандсан саналууд**

1. ОУИТБС-н портал, Орон нутгийн хөгжлийн сангийн мэдээллийг нэгтгэх;
2. Татвар, Нийгмийн даатгал, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт өгч байгаа тайланг ОУИТБС тайлантай холбох;
3. ОУИТБС-н жилийн нэгдсэн тайлан дээр мэдээлэл дутуу, чанаргүй байдаг. Нэгтгэл тайлан бэлтгэдэг ажлын даалгаврыг сайжруулах. Нэгтгэл тайлан хийж байгаа хөндлөнгийн аудиторын ажил сайжирвал дагаад бусад мэдээллүүд сайжирна.
4. Сангийн яамны датаг ажлын албан дээр төвлөрүүлж системийн шинэчлэл хийх. Ил тод байдлын тухай нэгдсэн мэдээллийн санг бий болгох. Татвар, шилэн данс, ОУИТБС-ийн бүх мэдээллийг нэгтгэх;